



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 5/11

Цэнхэрмандал сум

Э.Цэцэгнямыг ажилд томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 41, 47, 48, 49 дүгээр зүйл, 50 дугаар зүйлийн 50.1.4 дэхь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 12 сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоол, 2024 оны 82 дугаар тогтоол, 2018 оны 382 дугаар тогтоол, Боловсролын сайдын 2026 оны 01 сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаал, тушаалын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус хүүхдийн цэцэрлэгт Эрдэнэбатын Цэцэгнямыг 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн үйлчлэгчийн ажилд томилсугай.

2. Үйлчлэгч Э.Цэцэгнямд ТҮ-1 албан тушаалын цалин 1,431,000 (Нэг сая дөрвөн зуун гучин нэгэн мянга)-н төгрөгөөр цалинжуулахыг нягтлан бодогч Д.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

3. Үйлчлэгч Э.Цэцэгнямд холбогдох эд хөрөнгийг хүлээлгэн өгч, бүртгэл хөтлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Э.Сугармаа – Арга зүйч (Өмч хамгаалах
байнгын зөвлөлийн дарга)

Нарийн бичиг: Д.Пүрэвсүрэн - Нярав

Гишүүн: Г.Түвшинзаяа - Хөгжмийн багш (Өмч хамгаалах
байнгын зөвлөлийн гишүүн)

4. Хуульд заасан эрх үүргээ биелүүлж, холбогдох дүрэм журмыг чанд мөрдөн цаг баримталж, батлагдсан ажлын цагт ажил үүргээ бүрэн хариуцаж хариуцлага, санаачлагатай, ёс зүйтэй ажиллахыг үйлчлэгч Э.Цэцэгнямд үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ



П.ГАНТУЯА